



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар #130

Улаанбаатар хот

Голомтод халдваргүйжүүлэлт хийх
баг томилох тухай

Монгол улсын эрүүл мэндийн сайдын “Голомтод халдваргүйжүүлэлт хийх түр заавар” батлах тухай 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/188 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /COVID-19/-ын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед эцсийн халдваргүйжүүлэлт хийх багийг нэгдүгээр, голомтод халдваргүйжүүлэлт хийх түр зааврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Коронавируст халдвар /COVID-19/-ын үед голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг тухай бүр зохион байгуулан ажиллахыг хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч /Б.Шинэхүү/, төв амбулаторийн эрхлэгч/ Г.Цолмон/, Яармаг салбар амбулаторийн эрхлэгч /Г.Оюунцэцэг/ нарт үүрэг болгосугай.

3. Коронавируст халдвар /COVID-19/-ын үед голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх багуудыг мэргэжил арга зүйгээр ханган шаардлагатай багаж хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисын бэлэн байдлыг хангаж ажиллахыг тархвар судлаач /С.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай

4. Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд шаардлагатай багаж хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодис / автомакс, жавелион, хлорсепт, 76⁰-ын спирт, гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай уусмал гэх мэт/ -оор тасралтгүй хангах нөөцийг бүрдүүлэн ажиллахыг эм зүйч/Б.Ариунзул/-д үүрэг болгосугай


5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ


Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
 2020 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн
 30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх
 багийн бүрэлдэхүүн

№	Тасаг нэгжийн нэр	Багийн гишүүдийн нэр	Мэргэжил албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
1	Хэвтэн эмчлүүлэх тасаг	С.Өлзийжаргал	Тархвар судлаач	Мэргэжил арга зүйгээр хангаж хяналт тавих
2		Ц.Оюунцэцэг	Ариутгагч	Тухайн өрөө тасалгаанд халдваргүйжүүлэлтийг хийнэ
3		Т.Баярмаа	ХЭТ-ийн үйлчлэгч	Халдваргүйжүүлэлтийн дараах цэвэрлэгээ хийнэ
4		Даваажаргал	Угаагч	Зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлж угаах
1	Төв амбулатори	Ө.Ариунжаргал	Тархвар судлаач	Мэргэжил арга зүйгээр хангаж хяналт тавих
2		П.Оюунжаргал	Ариутгагч	Тухайн өрөө тасалгаанд халдваргүйжүүлэлтийг хийнэ
3		З.Отгонцацрал	Үйлчлэгч	Халдваргүйжүүлэлтийн дараах цэвэрлэгээ хийнэ
4		Н.Баярмаа	Угаагч	Зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлж угаах
1	Яармаг салбар амбулатори	Б.Цэндсүрэн	Тархвар судлаач	Мэргэжил арга зүйгээр хангаж хяналт тавих
2		М.Энхтуяа	Ариутгагч	Тухайн өрөө тасалгаанд халдваргүйжүүлэлтийг хийнэ
3		Р.Буянжаргал	Үйлчлэгч	Халдваргүйжүүлэлтийн дараах цэвэрлэгээ хийнэ
4		Д.Саранцэцэг	Угаагч	Зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлж угаах

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2020 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн
#1/30 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Голомтод халдваргүйжүүлэлт хийх түр заавар

Коронавируст халдвар /COVID-19/-ын тархалтаас сэргийлэх зорилгоор багийн гишүүд эцсийн халдваргүйжүүлэлт хийхдээ энэхүү зааврыг баримтална. Үүнд:

1. Тархвар судлаач эмч нь голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх багийг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж хяналт тавьж ажиллана
2. Томилогдсон багийн гишүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хэрхэн хийж гүйцэтгэх чиглэлээр сургалт хийж дадлагажуулсан байна.
3. Багийн гишүүд нэг удаагийн иж бүрэн хамгаалах хувцас хэрэгслийг нэг удаагийн малгай, шүүлтүүртэй амны хаалт, нүдний шил, нүүрний хамгаалалт, комбинзон, бээлий, ханцуйвч, түрийтэй усны гутал /нэмэлтээр хормогч, нэг удаагийн халад өмсч болно/ зэргийг халдваргүй бүс буюу ногоон бүсд өмсөнө.
4. Халдваргүйжүүлэх бодисыг зааврын дагуу найруулан хэрэглэнэ.
5. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг өвчтөний тусламж үйлчилгээ авсан тасаг кабинет зорчсон маршрутуудад болон тусгаарлах өрөө, зөөвөрлөсөн тээврийн хэрэгсэл зэрэгт хийнэ.
6. Халдваргүйжүүлэлт хийхээс өмнө өрөө тасалгааны цонх хаалгыг хаана.
7. Эцсийн халдваргүйжүүлэлт хийх байр, өрөө тасалгааны гадна тал хаалганаас эхэлж дотогш болон дээрээс доош чиглэлээр арчиж болон шүршиж халдваргүйжүүлэлтийг хийнэ.
8. Тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний эд зүйлсийн гадаргууг халдваргүйжүүлэх бодис бүхий алчуураар арчина.
9. Хоол хүнсний сав, аяга таваг зэргийг зориулалтын угаагч шингэн бүхий халуун усаар угаана.
10. Хамгаалах хувцас хэрэгсэл болон тусламж үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны явцад үүссэн халдвартай хог хаягдлыг шар уут бүхий хог хаягдлын зориулалтын тагтай саванд хийж савны гадна талыг халдваргүйжүүлэлтийн уусмалаар шүршиж зөөвөрлөн ЭМС-ын 505 тоот тушаалаар баталсан зааврын дагуу устгуулна.
11. Давтан хэрэглэх эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цэвэрлэж, халдваргүйжүүлэх, ариутгахдаа ЭМС-ын 2019 оны 537 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан зааврыг мөрдөнө.
12. Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг ЭМС-ын 537 дугаар тушаалын 8-р хавсралтаар баталсан зааврыг баримтлан халдваргүйжүүлэн угааж цэвэрлэнэ
13. Ойрын хавьтал, өвчтөн, цогцос зөөвөрлөсөн тээврийн хэрэгсэлд тухай бүр нь эцсийн халдваргүйжүүлэлтийг хийнэ.